

**ОРХОН АЙМГИЙН ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ЗӨВШЛИЙН ГУРВАН ТАЛТ 2023-2025 ОНЫ ХАМТЫН
ХЭЛЭЛЦЭЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2023 ОНЫ ХЭРЭГЖИЛТ
(ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР)**

2023 оны 12 дугаар сарын 05-ны өдөр

Орхон аймаг

№	Хэлэлцээрийн заалтын дагуу хэрэгжүүлэх арга хэмжээнүүд	Хэрэгжилтийг зохион байгуулах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт
1	4.1. Нийтийг хамарсан хорио цээр, гамшгийн үед дайчилгаагаар ажилласан эрүүл мэндийн болон хүчний байгууллагын ажилтнуудын хамгаалах хэрэгсэл, ажлын цагийн зохицуулалтыг хийхэд онцгойлон анхаарч илүү цагийн хөлсийг тухай бүрд нь орон нутгийн төсвөөс гаргаж, гүйцэтгэлд нь нийгмийн түншлэлийн талууд хяналт тавина.	Аймгийн ЗДТГ-ын СТСХ НБХ ОБГ ЭМГ ЦГ	АҮЭХ АОЭХ	Тайлант хугацаанд нийтийг хамарсан хорио цээр, гамшгийн үед дайчилгаагаар ажилласан тохиолдол байхгүй болно.
2	4.2. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтад аймгийн аж ахуйн нэгж, байгууллагуудыг хамруулан зохион байгуулж, хэрэгжилтэд нийгмийн түншлэлийн талууд хяналт тавина.	Аймгийн ЗДТГ-ын НБХ НДХ ХАБЭАЗ	ЭМГ АҮЭХ АОЭХ	Ажилтны эрүүл мэндийн хугацаат үзлэг, тандалтын арга зүй, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, мэргэжлээс шалтгаалах өвчний эрт илрүүлэлт, хөдөлмөрийн чадвар алдалтын урьдчилан сэргийлэлт, мэдээллийг сайжруулах чиглэлээр сургалтад эрүүл мэндийн байгууллагуудын удирдлага, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтан, хүний нөөцийн мэргэжилтэн нийт 39 хүн хамрагдсан. Тайлант хугацаанд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөл бүртгэгдээгүй. <i>Хэрэгжилт 70%</i>
3	5.1. Хорт хавдартай болон хүнд өвчтэй иргэдийн эмчилгээ, өндөр үнэтэй оношилгооны зардалд зориулж 1 удаагийн дэмжлэгийг орон нутгийн төсвөөс олгож, холбогдох эмнэлгүүдтэй хамтарч ажиллана.	Аймгийн ЗДТГ-ын НБХ ЭМГ	Сумдын ЗДТГ ХХҮГ БОЭТ	Хорт хавдартай иргэдийн эмийн зардалд дэмжлэг үзүүлэхээр аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд 70.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэснээс тайлант хугацаанд 109 иргэнд 43,2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. 2023 оны байдлаар хавдрын 159 тохиолдол бүртгэгдэж, хяналтад орсноос эмийн болон эмчилгээний дэмжлэгт 69,2 хувь нь хамрагдсан байна.

				<i>Хэрэгжилт 100%</i>
4	5.2. Эрүүл мэндийн даатгалаа төлсөн иргэд, ахмад настан, хүүхдүүд эмнэлэгт хэвтэж эмчлүүлэхэд эм тариа гаднаас өөрсдөөс нь гаргуулсан тохиолдолд мөнгийг нь холбогдох хуулийн дагуу олгосон эсэх талаарх мэдээллийг тогтмолжуулж, хэрэгжилтэд нь нийгмийн түншлэлийн талууд хяналт тавина.	Аймгийн ЗДТГ-ын НБХ	ЭМГ БОЭТ ХЭАХН ШӨХТГ	Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13.1.2 дахь заалт “Эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангах” гэсэн заалтын дагуу Бүсийн оношилгоо эмчилгээний төв болон магадлан итгэмжлэгдсэн хувийн хэвшлийн ор бүхий 12 клиник Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13.1.8 дахь заалтын дагуу даатгуулагчийг хэвтүүлэн эмчлүүлэх үед өвчний түүхэнд бичигдсэн бичигдсэн эм тариа, материалын зардлыг өөрөөр нь гаргуулсан тохиолдолд зах зээлийн жишиг үнээр тооцон иргэнд буцаан олгодог ба тайлант хугацаанд 3 иргэнд 1.2 сая төгрөгийн буцаан олголт хийгдсэн байна. <i>Хэрэгжилт 100%</i>
5	5.3. Сульдаатай, тураалтай хүүхдийн зуны чийрэгжүүлэх сувиллын үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгүүлэх, Хөдөлмөр халамж, үйлчилгээний газрыг түшиглэн хүсэлт гаргасан ахмад настныг ахмадын сувилалд амраах үйлчилгээг үзүүлнэ.	Аймгийн ЗДТГ-ын НБХ	ЭМГ ХХҮГ ХБИН	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 13/09 дүгээр тогтоолоор суурь өвчтэй хүүхдүүдийг чийрэгжүүлэх, гэр сувилал ажиллуулахаар 30.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдан, сонгон шалгаруулалтад “Уян чагнуур”ХХК шалгарч сульдаа, уураг илчлэгийн дутагдал, цус багадалт зэрэг суурь эмгэгтэй болон хөгжлийн бэрхшээлтэй 150 хүүхдийг нар, ус, агаараар чийрэгжүүлэх зуны сувилалд хамруулан эмчлэн, эрүүлжүүлсэн. <i>Хэрэгжилт 100%</i>
ДУНДАЖ ХУВЬ 92.59				

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Г.ЭНХЖАРГАЛ

ТАНИЛЦСАН:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.СҮХЭЭ